



НИЙСЛЭЛИЙН
БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 03 сарын 31 өдөр

Дугаар А/15

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсэг, Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/727 дугаар захирамж, Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан "Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-ыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт хийх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч

Захиргаа, төлөвлөлт, санхүүгийн
хэлтсийн дарга

Гишүүд

Захиргаа, төлөвлөлт, санхүүгийн
хэлтсийн Ахлах мэргэжилтэн

Спорт, нийтийн биеийн тамирын хэлтсийн
Ахлах мэргэжилтэн

Эрх зүй, тогтоол шийдвэр хариуцсан
мэргэжилтэн

Нарийн бичиг

Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод ажил
хариуцсан мэргэжилтэн

2. Дотоод хяналт шалгалтыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу зохион байгуулж, хагас бүтэн жилээр үр дүнг тайлагнаж, хяналт тавьж ажиллахыг ажлын хэсгийн ахлагчид даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



С.САРАНЦЭЦЭГ

